

**АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ-ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**  
(2022 оны эхний 10 сарын байдлаар)

2022.11.02

Эрдэнэт хот

№	Бодлогын үндэслэл	Арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		Төсөв	Зарцуулсан төсөв	Биелэлт	Тухайн жилийн үнэлгээ, хувь
			Суурь түвшин	Зорилтот түвшин				
1	2	3	4	5	6	7	8	9
<b>ХОЁР. ЭРҮҮЛ, БҮТЭЭЛЧ, ХӨГЖИХ ТЭМҮҮЛЭЛТЭЙ-ЭРДЭНЭТ ХҮН</b>								
<b>Зорилт 2.2.</b> Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.								
1	МУХЖТ 2.1.26 ТЖҮЧ 2.2.1 ЗДҮАХ 1.5	“Эмч” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь 95,3 хувь	Тухайн жилд төлөвлөгдсөн ажлуудын хэрэгжилтийг бүрэн хангасан байна.	Орон нутгийн төсөв 60.0 сая		Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар тогтоолоор “Эмч” хөтөлбөрийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаж орон нутгаас 60,0 сая төгрөгийг шийдвэрлэж, хөтөлбөрийн хэрэгжилт 96%-тай байна. - Гамшиг нийгмийн цаг үеийн байдалтай холбоотой дотоод сургалтад 1031 эмч, ажилтныг хамруулсан. - Австри улсын <u>Зайлцбург хотод</u> сургалтад 1 эмч, Япон улсад төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 3 сувилагчийг хамруулсан. - Дэлхийн эмч нар болон олон улсын сувилагчдын өдрийн хүрээнд Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж шилдэг 12 илтгэлийг шалгаруулсан. Судалгааны арга зүйн сургалтад 68 эмч, сувилагчийг хамруулсан. Эмч, сувилагчийн мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, алдаршуулах хүрээнд ажил мэргэжлийн уралдаан 1, хэлэлцүүлэг 1, <u>теле_нэвтрүүлэг</u> 4, аян 2 удаа зохион байгуулж, шилдэг 3 байгууллагыг шалгаруулсан. - Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, аймгийн болон эрүүл мэндийн салбаруудын удирдлага 70 гаруй хүний төлөөлөл оролцлоо. - Анагаахын Шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 80 жилийн ой хүрээнд багш шавийн уулзалтыг зохион байгуулж, 110 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. - БОЭТ-ийн “Ерөнхий мэргэшил судлал”-аар тайлант хугацаанд 1 резидент эмч, төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 16 сувилагч элсэн суралцаж	100

							<p>байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Англи хэлний чадварыг дээшлүүлэх сургалтад 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.</li> <li>- Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос тайлант хугацаанд 39 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1024, багц цагийн сургалтад 285 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа. Тайлант хугацаанд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд гомдол ирээгүй.</li> <li>- 40-ээс дээш насны 329 эрүүл мэндийн ажилтанд хавдрын маркер хийлгэж, 3 мэргэжилтнийг нарийн мэргэжлийн эмчид илгээсэн байна.</li> <li>- Төгсөлтийн дараах сургалтад эмч мэргэжилтнүүдийн 12,9% нь, нийгмийн дэмжлэгт нийт эрүүл мэндийн ажилтны 17% нь хамрагдсан байна.</li> </ul>	
2	ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг /хөх, умай, чихрийн шижин, цусны даралт ихсэх/ үзлэгийг эрчимжүүлэх	Эрт илрүүлэг үзлэгийн хамралт 30.0 хувь	Эрт илрүүлэг үзлэгийн хамралт 32 хувь	Орон нутгийн төсөв 12.0 сая		<p>Тайлант хугацаанд хөх, умайн хүзүү, элэгний хатуурал, хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэх зэрэг өвчний эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэхээр орон нутгаас 12,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Эрт илрүүлэг үзлэгийн дундаж хувь тайлант хугацаанд 32%-д хүргэхээр төлөвлөснөөс 34,2% байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 25909 буюу хамрагдвал зохих хүн амын 37,7 хувийг эзэлж, өмнөх оноос 3,3 хувиар буурч үр дүнгийн үзүүлэлтээр 0.7 хувь нь онош батлагдсан.</li> <li>- Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 16246 хамрагдвал зохих хүн амын 47,9 хувийг эзэлж, өмнөх оноос 8,6 хувиар буурч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.2 хувь онош батлагдсан байна.</li> <li>- Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 1675 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 30,1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 9,4 хувиар буурсан ба 1390 буюу 85.1 хувь нь пап шинжилгээнд хамрагдсан байна.</li> <li>- Хөхний эрт илрүүлэг үзлэгт 10357 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 30,1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 29,4 хувиар буурсан байна.</li> </ul> <p>Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, сэргийлэх чиглэлээр 35 төрлийн постер зөвлөмжийг 18569 иргэнд хүргэж, 3 өдөрлөгт давхардсан тоогоор 4786 иргэнийг хамруулан 6 эх бэлтгэл, 3 шторка бэлтгэн цахим хуудсаар иргэдэд хүргэсэн.</p>	70
3	МУТЖҮЧ 2.2.2	Хорт хавдартай иргэдийн эмийн	Дэмжлэгт хамрагдсан	Дэмжлэгт хамрагдсан хувь	Орон нутгийн	17,3 сая	Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн	100

	МУХЖТ 2.1.20 ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1	болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх	хувь 15.0 хувь	17.2 хувь	төсөв 70.0 сая		чиглэлд 70.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээс аймгийн Засаг даргын 2022 оны А/214, А/432, А/610 дугаар захирамжаар 2022 оны эхний 10 сарын байдлаар 130 иргэнд 47,5 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлээд байна.	
4	ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1	“Эрүүл хамт олон” ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, жил бүр шалгаруулан сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулах	Хамрагдсан ЭМДБ-ын тоо 66	Хамрагдах ЭМДБ-ын тоо 72	Орон нутгийн төсөв 6.0 сая	-	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, эрүүл ажлын байр шалгаруулах болзолт шалгуур болон эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг сурталчлан ажилласны үр дүнд 2022 онд 1 байгууллага шинээр, 2 байгууллага зэрэглэл ахиулахаар хүсэлт ирүүлж хамтран ажиллаж байна. Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 71 байгаагаас боловсролын байгууллага 42, үйлдвэр аж ахуйн нэгж 11, эрүүл мэндийн байгууллага 10, бусад 8 байна. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аян өрнүүлэх, эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн төсвөөс 6,0 сая төгрөгийг шийдүүлсэн. “Өдөр бүр 30 минутыг өөртөө” аяныг эрүүл мэндийн салбарын хэмжээнд өрнүүлж, эрүүл мэндээ дээдлэгч 14 ажилтныг олон нийтэд цахимаар сурталчлан 38904 иргэнд хүргэсэн байна.	83,3
5	МУТЖҮЧ 2.2.2 МУХЖТ 2.1.19 ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1	Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг нэмэлт аминдэмд хамруулах	Нийгмийн халамж шаардлагатай й жирэмсэн, хөхүүл эхийг аминдэмээр хангалтын хувь 10 хувь	Нийгмийн халамж шаардлагатай жирэмсэн, хөхүүл эхийг аминдэмээр хангалтын хувь 12 хувь	Орон нутгийн төсөв 5.5 сая	5,5 сая	Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмжүүлэхэд зориулж аймгийн Засаг даргын 2022 оны А/171 дугаар захирамжаар батлагдсан төсвийн хүрээнд 502 эхийг хамруулахаас эхний 10 сарын байдлаар 353 буюу 70%-ийг аминдэмжүүлээд байна. Аминдэмжүүлэлтэд хамрагдсан нийт 353 эхээс цус багадалттай 201 эх байгаа нь 57 хувийг, нийгмийн халамж дэмжлэг нэн шаардлагатай бүлгийн 95 эх байгаа нь 27 хувийг, биологийн эрсдэлтэй 11 эх байгаа нь 3 хувийг, эх барихын ужиг дутагдалтай 46 эх байгаа нь 13 хувийг тус тус эзэлж байна. Аминдэмжүүлэлтийн үр дүнг тандахад цус багадалттай эхийн 80% нь бүрэн эдгэрч 30%-ийн биеийн байдал сайжирсан байна. Тайлант хугацаанд: - Эхийн аминдэмийн төсөв өмнөх онтой харьцуулахад хоёр сая төгрөг буюу 40%-аар нэмэгдэж хамрагдах эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1,74 дахин өссөн. - Зорилтот бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн 27,4- ийг аминдэмжүүлэлтэд хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5%-аар нэмэгдсэн байна.	100
6	МУТЖҮЧ 2.2.2 МУХЖТ 2.1.19 ТЖҮЧ 2.2.3 ЗДҮАХ 1.2.4	Нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинжийн хувь 30.5 хувь	Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинжийн хувь 28.5 хувь	Орон нутгийн төсөв 58.5 сая	58,5 сая	Орон нутагт нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологиудыг амжилттай нэвтрүүлсэн. Үүнд: - Сурфактант эмчилгээг 2015 оноос эхлэн нярайн тусламж үйлчилгээнд нэвтрүүлж, тайлант хугацаанд амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 15 нярайд сурфактант эмчилгээг хийж, 86,6 хувийн үр дүн өгсөн байна. - Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг төрсөн 1678 нярайд 100 хувь үзүүлж хэвшсэн.	100

							<p>- Нярайн тандалт скрининг шинжилгээнд төрсөн нярай бүрийг 100% хамруулж байгаа бөгөөд түнхний үений ЭХО оношилгоонд 1910, ретинопатийн оношилгоонд 64 нярайг хамруулж, 2 нярайг лавлагаа шатлалд илгээсэн байна.</p> <p>Тайлант хугацаанд нярайн эндэгдлийн 6 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 3,1 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7,2 промиллоор буурсан ба нярайн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан болох амьсгал хямралын хам шинжийн шалтгаант эндэгдэл гараагүй байна.</p>	
7	ТЖҮЧ 2.2.3 ЗДҮАХ 1.2.1	Тархины харвалт, шигдээсийн нэгж байгуулах	Тархины харвалт, шигдээсийн нэгж байгуулах бэлтгэл ажлыг хангагдсан.	Шаардлагатай санхүүжилтийг төсөвт суулгах, үйл ажиллагааг тогтмолжуулна.	Улс болон орон нутгийн төсөв 33.0 сая		<p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэдрэл, дотор, эрчимт эмчилгээний тасагт хийгдэх бүлэн хайлуулах эмчилгээг нутагшуулах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 1 эмч, 1 сувилагч сургагдаж бэлтгэгдсэн.</li> <li>- Улсын төсвөөс ангиографийн аппаратаар хангагдан 200 хүнд оношилгоог хийснээр зүрхний цочмог шигдээс өвчний нас баралтыг бууруулсан.</li> <li>- Дотрын тасагт тархины харвалтын нэгж байгуулахаар бэлтгэлийг хангасан. Эрүүл мэндийн даатгалаас өндөр өртөгт хагалгааны зардал нэг иргэнд 4.9 сая төгрөгийг төлж байна.</li> <li>- Орон нутгаас 33,0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж 10 ширхэг бүлэн хайлуулах РЭПИ/актилизе/-р хангасан байна.</li> </ul>	100
8	МУТЖҮЧ 2.2.3 МУХЖТ 2.1.31 ТЖҮЧ 2.2.8	БОЭТ-ийн амбулаторийн тасагт засвар хийж, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх	-	Засвар хийгдсэн байна.	Орон нутгийн төсөв 200.0 сая	200,0 сая	Орон нутгийн 200,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Амбулаторийн 1 болон 2 давхрын их засварын ажил бүрэн хийгдсэн.	100
9	ТЖҮЧ 2.2.8 ЗДҮАХ 1.2.5	БОЭТ-ийн гадна инженерийн шугам сүлжээ, цахилгаан кабель шугамыг шинэчлэх	-	Гадна инженерийн шугам сүлжээ, цахилгаан кабель шугам шинэчлэгдсэн байна.	Улсын, Орон нутгийн төсөв 272.2 сая	272,2 сая	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар БОЭТ-ийн цахилгаан кабель шугамыг шинэчлэхэд 135,0 сая, гадна инженерийн шугам сүлжээний засварт 150.0 сая төгрөгийн ажлууд батлагдаж орон нутгийн Өмчийн газар гүйцэтгэгч компани болох "Аривлах" ХХК болон гэрээт "Маут Консалтинг" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл 80% байна.	100
10	ТЖҮЧ 2.2.5 ЗДҮАХ 1.2.3	Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх гэр сувилал ажиллуулах	Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэсэн байгууллага 1	Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.	Орон нутгийн төсөв 20.0 сая	20,0 сая	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит VI хуралдааны 06/04 дугаар тогтоолоор батлагдсан 2.4.103 дахь заалтаар 20,0 сая төгрөгөөр санхүүжих суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувилал ажиллуулах сонгон шалгаруулалтад "Уян чагнуур"ХХК-ын Бүжинлхам хүүхдийн клиник шалгарч тайлант хугацаанд зорилтот бүлгийн уураг	100

							илчлэгийн хурц болон архаг дутал, сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй 264 хүүхдийг нар, ус, агаараар чийрэгжүүлэн эмчилгээний хоол, сүү цагаан идээ, аминдэмжүүлэлтэд хамрууллаа. Чийрэгжүүлэлт, сувилгаанд хамрагдсан 100 хүүхдийн 87 /70.4%/ нь зөв хооллолт сувилгааны үр дүнд 100-500 гр жин нэмэгдэж, эмнэлзүйн хувьд хооллолтын бэрхшээл арилсан. Жин, өсөлтийн 1-р зэргийн хоцрогдолтой 56 хүүхэд, 2-р зэргийн 35 хүүхэд, 3-р зэргийн 4 хүүхдийн жингийн үзүүлэлт 200-500 гр нэмэгдэж 83 хувь нь жин, өсөлтийн үзүүлэлт дээшилсэн үр дүнтэй байна. Мөн COVID-19 холбоотой бага насны болон сургуулийн насны хүүхдүүдийн дунд дэлгэцийн хамааралтай ТИК НЕВРОЗ оноштой 2-16 насны 25 хүүхэд эмчилгээ, сувилгаа хийгдсэн байна.	
11	ТЖҮЧ 2.2.3 ЗДҮАХ 1.2.1	БОЭТ-д “ХӨТӨЧ” төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	-	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 100%	Орон нутгийн төсөв 84.5 сая	84,5 сая	Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2021 оны 11 дүгээр сараас “Хан шунхлай нуруу” ХХК-ийн 6 хөтөч сувилагчийг ажиллуулснаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 90% болж өмнөх оноос 15%-иар нэмэгдэж, иргэдийн тодорхойгүй, мэдээлэлгүй, ойлгомжгүй байдал 88,2 хувиар багассан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/105 дугаар захирамжаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дэргэд хэрэгжүүлж байгаа “Сэтгэлд нийцсэн хөтөч” үйлчилгээ ажиллуулахад дэмжлэг үзүүлж, 6 хөтөч сувилагчийн цалин, нэг удаагийн хэрэгсэлд 35,2 сая төгрөгийг шийдвэрлэсэн. “Хан шунхлай нуруу” ХХК-ийн Хөтөч үйлчилгээнээс 14 хоног тутам “Герман Монголын хамтын ажиллагааны нийгэмлэг”-ийн Froggress төслийн болон “Илтгэх урлагийн индэр” төрийн бус байгууллагатай хамтарсан төлөвлөгөөт сургалт, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран дохионы хэлний анхан шатны сургалтыг зохион байгуулан ажилласан. Хөтөч үйлчилгээний ажилтнууд суурь судалгаа, явцын судалгаа, хөндлөнгийн хяналт хийж нийт 28 санал, 4 иргэний гомдлыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлсэн. Үйл ажиллагаа эхэлснээс хойш 100,000 гаруй хүнд хөтчийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 90% болж өмнөх оноос 15%-аар нэмэгдсэн.	100
12	ТЖҮЧ 2.2.2. ЗДҮАХ 1.1	Хүн амд ДОХ/ХДХВ/БЗДХ-ыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх ажлыг эрчимжүүлэх	БЗДХ-ын тохиолдол 10,000 хүн амд 28,2 промилл	БЗДХ-ын тохиолдол 10,000 хүн амд 24.2 промилл	Орон нутгийн төсөв 12.0 сая		Тайлант хугацаанд 3850 иргэн бэлгийн замаар дамжих халдварын эрт илрүүлэг, оношилгоонд хамрагдсанаас 70,9% нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ХДХВ-ийн шинжилгээнд 1939, тэмбүүгийн шинжилгээнд 1961 иргэнийг хамруулсан. Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношлогооны хүрээнд ХДХВ/Тэмбүү	100

						<p>илрүүлэх шинжилгээнд хамрагдах 18-30, 31-45 насны 1026 иргэн эрт илрүүлэг, шинжилгээнд хамрагдаж 4.2%-д тэмбүү өвчин оношлогдож БОЭТ-ийн ДОХ/БЗДХ-ын кабинетэд эмчилгээнд хамруулахаар илгээсэн. ДОХ/ХДХВ/БЗДХ-ыг эрт илрүүлэг, оношилгооны хамрагдалтыг эрчимжүүлэхээр 7 төрлийн зурагт хуудсыг цахим орчинд байршуулан 13240 хүнд хүргэсэн байна.</p> <p>Тайлант хугацаанд бэлгийн замаар дамжих халдварын 147 тохиолдол бүртгэгдсэнээс 48,9%-ийг тэмбүү, 23,1%-ийг заг хүйтэн, 2,79%-ийг трихомониаз тус тус эзэлж, нийт халдварт өвчний 3,1%-ийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0,8%-аар өсч, 10 000 хүн амд 13,9 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 1,8 промиллоор тус тус буурсан байна.</p>	
13	ТЖҮЧ 2.2.4. ЗДҮАХ 1.3	Амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах	-	Бэлэн байдал хангагдсан байна.	Орон нутгийн төсөв 150.0 сая	<p>Тайлант хугацаанд амьсгалын замын халдварт өвчний 4091 тохиолдол бүртгэгдсэнээс 97,5%-ийг коронавируст халдвар, 1.2%-ийг сүрьеэгийн халдвар, 1,3%-ийг бусад халдварт өвчин эзэлж байна. Бэлэн байдлыг хангах чиглэлээр томуу, томуу төст, коронавируст халдварын бэлэн байдал, хариу арга хэмжээний аймгийн хэмжээний төлөвлөгөө боловсруулан салбар байгууллагуудад хүргүүлэн хамтран ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 80%-тай байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 7 хоног бүр тархалтын түвшний үнэлгээ хийж ажилласан. Томуу томуу төст өвчин 10 000 хүн амд 103.5, түргэн тусламжийн 297 дуудлагаас (88) 29.63%-ийг ТТӨ шалтгаант дуудлага эзэлж байна. Аймгийн хэмжээнд ТТӨ алаг доог дэгдэлтийн түвшинд байна.</li> <li>- Лабораторийн тандалтыг эрчимжүүлэх чиглэлээр 7 хоног бүр тандалтын нэгжүүдээс сорьц цуглуулан томуугийн үүсгэгч илрүүлэх ПГУ шинжилгээ хийж байна.</li> <li>- Улирлын томуугийн эсрэг эсрэг дөрвөн цэнт вакциныг 13750 хүн тун татан авч, зорилтот бүлгийн 3794 хүнийг хамруулж, хамралт 27,6% байна. Үүнд: 1-5 насны хүүхэд 2686, 65-аас дээш насны 852, эрүүл мэндийн байгууллагын ажилтан 247, жирэмсэн 9 хамрагдаад байна.</li> <li>- Амьсгалын замын халдвар өвчний үеийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуурын нөөц дунджаар 54 хоногийн нөөцтэй байна.</li> <li>- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийт 150,0 сая төгрөгийг амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангахаар шийдвэрлэсэнээс Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэргээн засах эмчилгээнд 100.0 сая төгрөг, өрхийн эрүүл</li> </ul>	100

							мэндийн төвүүдэд 50,0 сая төгрөгийн билиметр болон УВЧ шарлагын аппарат зэрэг шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангагдахаар орон нутгийн өмчийн газар тендер зарлагдаж “Мед Буян” ХХК шалгарч нийлүүлэгдсэн.	
14	МУТЖҮЧ 2.2.2 МУХЖТ 2.1.20 ТЖҮЧ 2.2.2. ЗДҮАХ 1.1	Хавдраас сэргийлэх арга хэмжээ	-	Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 90%	Орон нутгийн төсөв 30.0сая		Тайлант хугацаанд хорт хавдрын шинэ тохиолдол 168 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 13 тохиолдлоор буурч, эрт үедээ оношлогдсон хувь 49,4% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15,2%-аар нэмэгдсэн. - Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 1675 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 30,1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 9,4 хувиар буурсан ба 1390 буюу 85.1 хувь нь пап шинжилгээнд хамрагдсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 10357 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 30,1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 29,4 хувиар буурсан байна. - Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 1422 хүн хамрагдаж, хамрагалт 4.8 хувьтай, шинээр 3 хавдар оношлогдсон. Хавдрын хими эмчилгээнд 212 хүн хамрагдаж өмнөх оны мөн үеэс 38 тохиолдлоор их байна. Хавдраас урьдчилан сэргийлэх чиглэлээр 162 сургалтад 5943 иргэнийг хамруулж, 32 төрлийн сурталчилгааны материалыг цахимд байршуулахын зэрэгцээ 7380 иргэнд түгээсэн байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 09/05 дугаар тогтоолоор хавдраас урьдчилан сэргийлэх зардалд 30,0 сая, хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр 70.0 сая төгрөгийг баталсан. Тайлант хугацаанд 130 хорт хавдартай иргэнд 47,5 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлээд байна. Араг хэмжээний төлөвлөгөөний хувь 85% байна.	85%
15	ТЖҮЧ 2.2.2. ЗДҮАХ 1.1	Сүрьеэгийн эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээг сайжруулан, тандалт, судалгааг зохион байгуулах	-	Тандалт, судалгаа зохион байгуулагдсан байна.	Орон нутгийн төсөв 5.0 сая		Тайлант хугацаанд сүрьеэгийн үзлэгт нийт 8859 хүн хамруулснаас 87,5% нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан байна. Сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэг шинжилгээг эрчимжүүлэхээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран 186-р цэргийн ангийн 168 хугацаат цэрэг, алба хаагч, Эрдэнэт үйлдвэрийн 26 ажилтан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын нээлттэй 427-р хорих ангийн албан хаагч болон хүмүүжигч 198 хүнийг хамруулснаас идэвхтэй сүрьеэ 14 тохиолдол илэрч эмчилгээнд хамрууллаа. Сүрьеэгийн диспансерын хяналтад 55 өвчтөн эмчлэгдэж байна. Эмчилгээний амжилт 79%-тай байна. Тайлант хугацаанд сүрьеэгийн өвчлөл 48	100

						<p>бүртгэгдэж, 10000 хүн амд 4,5 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0,9 промиллоор нэмэгдсэн байна. Тус хугацаанд тандалт судалгаа 2 хийгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 4 жилд бүртгэгдсэн сүрьеэгийн шинэ тохиолдлуудын дунд тандалт, судалгаа хийхэд тохиолдлын тоо 5 болон 10 саруудад босго үзүүлэлтээс дээгүүр, эрэгтэйчүүдийн сүрьеэгийн тохиолдол эмэгтэйчүүдтэй харьцуулахад 40%-аар илүү бүртгэгдсэн бөгөөд өвчлөл 15-29 нас, 65-аас дээш насныхны дунд өндөр, нас баралт 60-аас дээш насныхан дунд их, нийт бүртгэгдсэн тохиолдлын 61% -д уушгины сүрьеэ илэрч байгаа нь цаашид сүрьеэгийн халдвар өсөх хандлагатай байгааг харуулж байлаа.</li> <li>- Сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос хавьтлын үзлэг шинжилгээнд зарцуулагдах 1.4 сая төгрөгийг шийдвэрлэн сүүлийн 4 жилийн сүрьеэ өвчин батлагдсан 270 иргэний ойрын хавьтлын 325 иргэнийг өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран дижитал рентген болон сүрьеэ илрүүлэх асуумжид хамруулснаар сүрьеэгийн сэжигтэй 8 тохиолдлыг илрүүлж цэрний түрхцийн шинжилгээнд илгээснээс 1 эерэг, уушгины сөрөг 2, хавдар 1 тохиолдлыг илрүүлсэн.</li> </ul>	
16	ТЖҮЧ 2.2.2. ЗДҮАХ 1.1	Зорилтот бүлгийн 16-49 насны эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан эмчлэн эрүүлжүүлэх	Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь 10	Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь 15	Орон нутгийн төсөв 5.0 сая	Тайлант хугацаанд өсвөр үе, зорилтот бүлгийн 546 эмэгтэйг нөхөн үржихүйн насны 4640 эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэг, сургалтад хамруулсан нь нийт нөхөн үржихүйн насны эмэгтэйн 18,5 %-ийг эзэлж зорилтот түвшинд хүрсэн. 16-49 насны эмэгтэйчүүдийн 62,1 хувь гэр бүл төлөвлөлтийн 5 төрлийн арга хэрэгсэлд хамрагдаж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4,5 хувиар нэмэгдсэн байна.	100
<b>ЕС. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b>							
<b>Зорилт 9.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.</b>							
17	МУТЖҮЧ 2.4.1 МУХЖТ 1.1.1 ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1.3	Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга чадавхыг орон нутгийн түвшинд бэхжүүлэх	Нөөцийн хангалт -50 хувь ЭМБ-ын хүний нөөцийн чадавх-70 хувь Багаж тоног төхөөрөмжийн хангалт -80 хувь	Нөөц хангалт-75 хувьд хүрсэн байна. ЭМБ-ын хүний нөөцийн чадавх-85 хувь Багаж тоног төхөөрөмжийн хангалт -85-90 хувьд хүргэх		Эрүүл мэндийн гамшгийн нөөцийг нэмэгдүүлж Эрүүл мэндийн яамнаас 2 удаагийн 202,0 сая төгрөгийн нөөц хангалт хийгдсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 199,6 сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэл олгож нөөцийг нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалт 83,3%-тай, 32 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оноос 31,2%-аар нэмэгдсэн байна. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцөд 12 төрлийн 138 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис байгаа ба нөөц хангалт, бүрдүүлэлт 80%-тай, өмнөх оноос 3 дахин их байна. Орон нутгаас 30,0 сая төгрөгийн санхүүжилтээр /өвлийн хээрийн	100



						<p>майхан, халдаг гудас, зөөврийн эвхдэг ор/ нөөцийн хангалтыг нэмэгдүүлсэн.</p> <p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 92%, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 98%-тай байна. Гамшгийн үеийн чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн албаны төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтын үеэр танхимын сургалт 3 удаа, мэргэжлийн ангийн дадлага сургуулилтыг 4 удаа хийж, хээрийн эмнэлэг дэлгэж жагсаалын үзлэгт “Онц” үнэлгээгээр дүгнэгдсэн. Хариу арга хэмжээний чадавх 90%-тай болсон нь өмнөх оноос 15%-аар нэмэгдсэн байна.</p>	
18	МУХЖТ 1.1.7 ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1.3	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, иргэдийн дундах угтан сэргийлэлтийн арга хэмжээг өргөжүүлэх /дархлаажуулалт, амин дэмжүүлэх, угтах эмчилгээ/	Зорилтод бүлгийн хүн амын дархлаажуулалтын хамралт -30 хувь Зорилтот бүлгийн иргэдийн 11.5 хувийг аминдэмжүүлэх, угтах эмчилгээнд хамруулсан.	Дархлаажуулалт өмнөх оны түвшингөөс 5-10 хувиар нэмэгдсэн байна	Зорилтот бүлгийн 46.4 хувь хамруулсан байна.	<p>Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд явуулаар дархлаажуулалт хийх хуваарийг аймгийн Засаг даргаар батлуулан, үүрэгжүүлэн ажилласан.</li> <li>- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эмч, вакцинолог сувилалч 36 хүнийг 2 удаагийн сургалтад хамруулсан.</li> <li>- Дархлаажуулалтын байнгын 10, явуулын 9 цэг, 3 түр цэг байгуулан ажилласан.</li> <li>- Вакцины үр дүн, ач холбогдлыг таниулах ганцаарчилсан зөвлөгөөг 1479 хүнд, утсаар 2110 хүнд өгч, 5867 иргэний цахим бүртгэлийг хянаж, дутуу болон алдаатай бүртгэгдсэн 131 иргэний мэдээллийг программд нөхөн оруулсан.</li> <li>- Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэлийн бага хурал 1, зөвлөмж мэдээлэл 4 удаа хийгдсэн. Нээлттэй хаалганы өдрийн хүрээнд 1000 гаруй иргэнд мэдээлэл, сурталчилгаа хийн, 25 иргэнийг вакцинд хамруулсан.</li> <li>- Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын 3-р тунд 37666/57,9%/, 4-р тунд өссөн дүнгээр 5489/15,8%/ иргэн хамрагдсан.</li> <li>- 5-11 насны хүүхдийг коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг ЭМГ-ын даргын А/63 дугаар тушаалаар зохион байгуулж, дархлаажуулалтыг эрчимжүүлэх чиглэлээр 2 удаагийн сургалт хийж, 27 эмч, вакцинолог хамрагдсан. Дархлаажуулалтад 196 хүүхэд хамрагдсан.</li> <li>- Угтан сэргийлэлтийн арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн 2598 хүнийг аминдэмжүүлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн халамж нэн шаардлагатай 353 эхийг орон нутгийн 6 сая төгрөгийн</li> </ul> </li> </ul>	100

							<ul style="list-style-type: none"> <li>- 100 хүүхдийг ГБХЗХГ-тай хамтран 2,0 сая төгрөгийн</li> <li>- Улс болон хувийн 37 цэцэрлэгийн ахлах бүлгийн 2145 хүүхдийг орон нутгаас 28,7 сая төгрөгийн аминдэмээр тус тус аминдэмжүүлсэн.</li> </ul> <p>Зорилтот бүлгийн хүн амын дархлаажуулалтын хамралт суурь үзүүлэлтээс 27.9%-аар нэмэгдэж, зорилтот бүлгийн 47%-ийг угтан сэргийлэлтэд хамруулсан байна.</p>	
19	ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1.3	Коронавируст халдварын дараах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрөл, материаллаг баазыг нэмэгдүүлж иргэдийг эрүүлжүүлэх, урт хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээнд хамруулах	Нийт батлагдсан тохиолдлоо с – 5203 /30 хувь/ ковидын дараах эмчилгээнд хамрагдсан.	Нийт батлагдсан тохиолдлын 50%-ийг хамруулсан байна. /10354 /			<p>Коронавируст халдварын дараах сэргээн засах тусламж үйлчилгээг өргөжүүлэн ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- БОЭТ-ийн амбулаторийн тасагт шинээр Ковидын дараах сэргээн засах кабинетыг нээн ажиллуулж 650 иргэнийг ковидын дараах сэргээн засах эмчилгээнд хамруулсан.</li> <li>- Орон нутгаас Ковидын дараах сэргээн засах тусламж үйлчилгээг нэмэгдүүлэхээр 100 сая төгрөгийг шийдвэрлэж Бүсийн оношилгоо эмчилгээний төвд уушгины багтаамж сайжруулах аппарат, бусад сэргээн засах багаж тоног төхөөрөмж авсан.</li> <li>- Эрдэнэт сувилалд 3 багцаар ковидын дараах сэргээн засах эмчилгээнд 250 иргэнийг хамруулсан.</li> <li>- Хувийн хэвшлийн Мөнхийн үйлс, Ачит, Их тавт, Тайхар, Мажаа, Очир-Увидас клиникүүдэд ковидын дараах уламжлалт, сэргээн засах, сэтгэл засал эмчилгээнд 1936 хүнийг хамруулсан.</li> </ul> <p>Тайлант хугацаанд коронавируст халдварын батлагдсан 3988 тохиолдол бүртгэгдсэнээс 2836 буюу 71.1% ковидын дараах сэргээн засах эмчилгээнд хамрагдсан байна.</p>	100
20	МУХЖТ 1.1.7 ТЖҮЧ 2.2.2 ЗДҮАХ 1.1.3	Цар тахлаас үүдэлтэй засаг, эрдэлт үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх эдийн нийгмийн бүлэгт тусламж	Зорилтот бүлгийн 20 хувь хамрагдсан.	Зорилтот бүлгийн 40 хувийг хамруулсан байх.	40	Орон нутгийн төсөв 250.0 сая	<p>Тайлант хугацаанд зорилтот бүлгийн 61%-ийг угтан сэргийлэлт болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ГБХЗХГ-тай хамтран 2,0 сая төгрөгийн төсвөөр зорилтот бүлгийн 100 хүүхдийг аминдэмжүүлсэн.</li> <li>- Томуу, томуу тест өвчний улирал эхэлсэнтэй холбоотой эрсдэлт бүлгийн 4-5 насны хүүхдүүдэд аймгийн Засаг даргын 2021 оны А/616 тоот захирамжаар батлагдсан 28,7 сая төгрөгийн төсвийн хүрээнд 1028 хайрцаг /иммуновис №60/ аминдэмийг авч, Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/142 тоот тушаалын дагуу улсын болон хувийн нийт 37 цэцэрлэгийн ахлах бүлгийн 2145 хүүхдүүдэд олгосон.</li> <li>- Нийгмийн халамж шаардлагатай жирэмсэн, хөхүүл 353 эхийг аминдэмжүүлэлтэд хамруулсан нь зорилтот бүлгийн 75%-ийг эзэлж байгаа ба үр дүн 83,3%-тай байна.</li> <li>- Жирэмсний эрт үеийн хяналтад 1244 эмэгтэй хамрагдаж</li> </ul>	100

							<p>96,5%-тай байгаа ба эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өсвөр үе, зорилтот бүлгийн эмэгтэйн 18,5%-ийг урьдчилан сэргийлэх үзлэг, сургалтад хамруулсан.</li> <li>- Бүжинлхам хүүхдийн клиникийн сувилалд зорилтот бүлгийн уураг илчлэгийн хурц болон архаг дутал, сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй 264 хүүхдийг нар, ус, агаараар чийрэгжүүлэн эмчилгээний хоол, сүү цагаан идээ, аминдэмжүүлэлтэд хамруулж, үр дүн 85%-тай байна.</li> </ul>	
Хэрэгжилтийн дундаж хувь-82,65%								

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.ЭНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ